

АТАР-ӨРГӨӨ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛЭГЧДИЙН
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2016.04.08

Улаанбаатар хот

“Атар-Өргөө” хувьцаат компанийн Хувь нийлүүлэгчдийн ээлжит хурал 2016 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн 10 цаг 00 минутад компанийн хурлын танхимд эхлэв.

Хурлыг ккомпанийн ТУЗ-ын гишүүд удирдаж, хурлын тэргүүлэгчид Б.Мөнхдалай, Ж.Сайнжаргал, Ч.Тогтохбаатар, Б.Ганбат, П.Аюурзана, Г.Баттулга, Б.Мөнхзаяа, Д.Даваадорж, Д.Гончигдорж нар байраа эзэлсний дараа Б.Мөнхдалай хурлыг нээж Хувь нийлүүлэгчдийн хурлын нарийн бичгийн даргын хэсэг, тооллогын комисс томилсон ТУЗ-ийн тогтоолуудыг уншиж танилцуулан комиссын ажилдаа орохыг мэдэгдэв.

Хурлыг ТУЗ-ийн дарга Б.Мөнхдалай даргалав.

Хурлын нарийн бичгийн даргын хэсэгт –П.Оюун-Эрдэнэ, Л.Энхсайхан

Тооллогын комисст- Н.Паламдорж, В.Баттуяа, Д.Гончигдорж нар тус тус ажиллав.

Тооллогын комисс хуралд ирсэн хувьцаа эзэмшигчдийг бүртгэн баталгаажуулж хурлын ирцийг гарган танилцуулав.

Тооллогын комиссын дарга Н.Паламдорж хурлын ирцийг 10 брокерийн пүүсээс 20 харилцагчийн 157980 хувьцааны саналаар 92,048 хувийн ирцтэй байна. Үүнээс биеэр 17 хувь нийлүүлэгч байгаа тухай мэдээллээ.

Хурлын ирц хангалттай байгаа тул хурлын дарга Б.Мөнхдалай хурлын дотоод журам, хэлэлцэх асуудлыг танилцуулж хурлыг 2 цагт багтаан хуралдуулахаар хувь нийлүүлэгчдийн саналыг гар өгүүлэн батлав.

Хурлын дотоод журмын дараах байдлаар батлав.

№	Хэлэлцэх асуудлын дэс дараалал	Хариуцах эзэн	Хугацаа
1	Хурлын ирцийг бүртгэж мэдээлэх	Тооллогын комисс	10 минут
2	Хурлыг нээх, тооллогын комиссыг тогтоолоор батлаж танилцуулах, хурлын нарийн бичгийн даргын хэсгийг томилох	ТУЗ-ийн дарга, Ерөнхий захирал	15 минут
3	2015 оны компанийн үйл ажиллагааны тайлан цаашдын зорилт	ТУЗ-ийн дарга, Ерөнхий захирал	15 минут
4	Санхүүгийн тайлан тэнцэл ашиг хуваарилалтын тухай, хараат бус аудитын дүгнэлт	Ерөнхий нябо	15 минут
5	Төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын хорооны мэдээлэл, дүгнэлт	ТУЗ-ийн Аудитын хорооны дарга	10 минут
6	Зохион байгуулалтын асуудал	Хуралд оролцогсод	Цаг тогтоохгүй
7	Санал шүүмжлэл	Хуралд оролцогсод	Цаг тогтоохгүй
8	2015 оны цэвэр ашгаас Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах	Хуралд оролцогсод	
9	Компанийн 2016 оны удирдлагын болон үйл ажиллагааны зардлын төсөв батлах	Хуралд оролцогсод	
10	Хурлаас гарах шийдвэрийг батлуулах	Нарийн бичгийн хэсэг	

Хурлаар хэлэлцэх асуудал

1. Компанийн үйл ажиллагааны 2015 оны тайлан, цаашдын зорилт
2. Санхүүгийн тайлан, ашиг хуваарилалтын тухай мэдээлэл
3. ТУЗ-ийн Аудитын хорооны мэдээлэл
4. Зохион байгуулалтын асуудал
5. 2015 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас “Ногдол ашиг хуваарилах тухай” ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах
6. Компанийн 2016 оны удирдлагын болон үйл ажиллагааны зардлын төсөв батлах

Хурлын дотоод журмын дагуу ТУЗ-ийн дарга Б.Мөнхдалай 2015 оны үйл ажиллагааны тайланг тавьлаа.

Б.Мөнхдалай- Атар-Өргөө ХК-ийн эрхэм хувьцаа эзэмшигч, харилцагч, хамтран ажилладаг нийт байгууллага, аж ахуйн нэгж, иргэд та бүхэнд улиран одсон 2015 оны ажлын амжилт, бүтээлээ дүгнэн хэлэлцэхэд таатай байна.

2015 онд манай хамт олон үйлдвэрлэлт, борлуулалтын үйл ажиллагаагаа өргөжүүлэх, түгээлтийн системээ сайжруулахад түлхүү анхаарч ажилласан бөгөөд нийт үйлдвэрлэлт, борлуулалтын төлөвлөсөн төлөвлөгөөгөө 101 хувиар биелүүлж ажиллалаа.

Тайлант онд тус компани нь Монгол улсынхаа эдийн засаг, зах зээлийн өсөлт, хөгжлийн бодлоготой уялдуулан бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн баталснаар борлуулалтын үйл ажиллагааг тэлэх, эдийн засагт санхүүгийн чадвахаа нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, оновчтой түгээлтийн үйлчилгээг нэвтрүүлэх өргөн боломжоор хангаж өгсөн тухай тодорхой цохон тэмдэглэн хэлсэн болно.

Тайлант онд Төлөөлөн удирдах зөвлөл Компанийн хувь нийлүүлэгчдийн ээлжит хурлыг хуулийн хугацаанд 2015.04.17-ны өдөр зарлан хуралдуулж хурлаар хэлэлцсэн асуудлыг хуралд оролцогчдын дийлэнх олонхийн саналын эрхээр шийдвэрлэсэн байна.

Төлөөлөн удирдах зөвлөл нь 2015 онд хувьцаа эзэмшигчдийн хурлаас дэвшүүлсэн зорилт, шийдвэрийг биелүүлж бүрэн эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулж тайлангийн хугацаанд ТУЗ-ийн хурлыг 12 удаа хуралдуулж, хурлаар 17 тогтоол шийдвэр гаргаж ажиллаа.

Төлөөлөн удирдах зөвлөл түүний дэд хороод хууль эрх зүйн хүрээнд Хувь нийлүүлэгчдийн оруулсан хөрөнгийг зөв зохистой захиран зарцуулан, тэдний эрх ашгийг хамгаалан үйл ажиллагааны голлох шийдвэрүүдийг гарган хэрэгжилт биелэлтэнд хяналт тавьж ажилласан болно. Өнгөрсөн оны тайланд 2012 оноос 2014 онуудад хувьцааны үнэ ханшийн тасарлтгүй өсөлтийн талаар танилцуулж байсан. 2015 он эдийн засгийн хямрал бидний үйл ажиллагаанд нөлөөлж байсан хэдий ч бид хувьцааны үнийг тогтвортой байлгах тал дээр нэлээдгүй анхаарч компанийн үнэ цэнийг алдагдуулалгүй ажиллаж ирсний дүнд хувьцааны үнэнд томоохон өөрчлөлт ороогүй хэлбэлзэл багатай байж чадсан тухай цохон хэллээ.

Компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд “Далай ван аудит” ХХК-ийг сонгон гэрээний дагуу аудитын бүрэн шалгалтыг хийлгэсэн болно.

Компанийн ногдол ашгийн бодлого, журмын дагуу тайлант онд Хувь нийлүүлэгчдэд 51,5 сая төгрөгийн ногдол ашгийг 171627 ширхэг энгийн хувьцаанд хуваарилан Үнэт цаасны төлбөр тооцооны төвлөрсөн хадгаламжийн төв ХХК-иар дамжуулан олгож Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн биржид тайлагнасан.

Санхүүгийн тайлан тэнцэл аж, ахуй нэгжийн орлогын, хувь хүний орлогын, авто тээвэр өөрөө явах хэрэгслийн, нэмэгдсэн өртөгийн албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл тайлан зэргийг хуулийн хугацаанд нь гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлэн баталгаажуулж ажиллаа.

Улсын төсөвт нийт 1,7 тэрбум төгрөгийн татвар, шимтгэл, хураамж төллөө. Тайлант онд тус компани нь Монгол улсынхаа эдийн засаг, зах зээлийн өсөлт, хөгжлийн бодлоготой уялдуулан бүтэц зохион байгуулалтыг өөрчлөн баталснаар борлуулалтын үйл ажиллагааг тэлэх, эдийн засагт санхүүгийн чадвахаа нэмэгдүүлэх, шинэ бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, оновчтой түгээлтийн үйлчилгээг нэвтрүүлэх өргөн боломжоор хангаж өглөө.

2015 онд үндсэн хөрөнгөд дахин үнэлгээ хийлгэсэн бөгөөд оны эцсээр “Атар-Өргөө” ХК-ийн нийт хөрөнгө 10,4 тэрбум төгрөг болсон байна. Хөрөнгийн дахин үнэлгээний үр дүн нь бид хөрөнгөө өнөөгийн бодит үнэ цэнээр үнэлж, баланздаа тусгаж хувь нийлүүлэгчдийн хөрөнгийг үндэслэлтэй илэрхийлэх зорилготой юм. Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээнд нийт 28 нэрийн барилга байгууламж, 239 нэрийн 537 ширхэг тоног төхөөрөмж, 57 нэрийн тээврийн хэрэгслийг хамруулсан болно.

2015 онд 530,5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө худалдаж авсан бөгөөд энэ нь өөрийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөрөнгө оруулалт юм. Хөрөнгө оруулалтаар худалдан авсан томоохон үндсэн хөрөнгө гэж: Нарийн боовны шугам, бөөрөнхийлөгч машин, цагираг боовны хэвлэгч машин, элдэгч машин, дулааны ялтсан бойлер, дулааны бөмбөлгөн хаалт, ачиж буулгах погрушик зэргийг худалдан авсан тухай хэлсэн.

Цааш нь борлуулалт, үйлдвэрлэлтийн тухай тайлагнав. Тэрээр 2015 оны эцсээр “Атар-Өргөө” ХК-ийн нийт хөрөнгө 10,4 тэрбум төгрөг, үйл ажиллагааны нийт орлого 13,1 тэрбум төгрөг, үүнээс 17,3 хувийг зээлээрх борлуулалт эзэлж байна. Нийт үйл ажиллагааны зардал 12,2 тэрбум төгрөг буюу нийт цэвэр орлогын 93 хувийг эзэлж байгаа тухай танилцуулав. 2016 онд 6252,8 тонн бүтээгдэхүүн үйлдвэрлэн борлуулж 1,1 тэрбум төгрөгийн цэвэр ашиг олохоор бизнес төлөвлөгөөний дагуу ажиллаж байна. Төлөвлөсөн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтаас гадна зорилтот төлөвлөгөөг үндсэн төлөвлөлтөөс гадна батлан гаргалаа. Нийт 8 нэр төрлийн бүтээгдэхүүнийг сонгон авсан ба сав баглаа боодол, амт чанар, стандарт зэргийг нарийн төлөвлөж өгсөн ба 6-р сараас худалдаанд гарч эхлэх болно. Зорилтот 8 нэрийн 160 тонн бүтээгдэхүүн нэмж борлуулан 68,9 сая төгрөгийн цэвэр ашигийг тухайн бүтээгдэхүүнээс олохоор төлөвлөн ажиллаж байгаа гэв.

2015 онд “Атар” нэрийн 9 дэлгүүр, 11 сүлжээний 100 гаруй дэлгүүр, 40 гаруй цэцэрлэг болон 60 гаруй аж ахуй нэгж, байгууллагуудтай гэрээний дагуу хамтран ажиллаж 2004 цэгт түгээж, үйлчилж ажиллаа.

Тайлант оны үйл ажиллагааны нийт орлого 13,1 тэрбум төгрөг, үүнээс 17,3 хувийг зээлээрх борлуулалт эзэлж байна. Үйл ажиллагааны зардал 12,2 тэрбум төгрөг буюу нийт цэвэр орлогын 93 хувийг эзэлж байна. Тайлант хугацаанд нийт 665.6 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна гэж хэлсэн.

Техник, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний талаар цааш нь танилцуулав. Тайлант онд тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тогтмол хийж байсан тухай нэг бүрчлэн танилцуулсан бөгөөд 223,7 сая төгрөгийг зарцуулсан тухай хэлсэн. Үүнээс гадна үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах үүднээс тоног төхөөрөмжүүдийн төлөвлөгөөт болон урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт тосолгоо, засварыг графикын дагуу тогтмол хийж байсан болно. Итгэмжлэгдсэн лабораторийн тухай Манай компанийн ISO/IEC 17025-2007 Итгэмжлэгдсэн лабораторийн итгэмжлэлийг 2015.05.20-ны өдрөөс 2 жилийн хугацаатайгаар сунгуулан ажиллаж байна. Лаборатори нь түүхий эдийн хими, нян судлалын шинжилгээ болон бүтээгдэхүүний сорилт шинжилгээг мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэж байгаагаас гадна чанар болон технологийн хяналт, жингийн хяналт, ажилтнуудын ариун цэвэр, халдваргүйжүүлэлт, хэмжих хэрэгслийн баталгаажуулалт, сав баглаа боодлын шинжилгээ зэргийг тогтмол хуваарийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Гадны байгууллагаас нийлүүлж байгаа түүхий эдийн гарал үүслийн болон шинжилгээний дагалдах бичгийг үндэслэн авч итгэмжлэлийн хүрээнд холбогдох шинжилгээг стандартын дагуу хийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэнд ашигладаг болно. Бүтээгдэхүүний үндсэн түүхий эд бараа материалыг “Алейк импекс”, “Алтан тариа”, “Мон масло”, “Хангайн гурил”, “Мон давс”, “Окиенский”, “Балт цент”, “Арслангийн удам” зэрэг томоохон байнгын харилцагч байгууллагуудаас нийлүүлж ирлээ. Лабораторийн шинжээч нарын ур чадварыг сайжруулах үүднээс холбогдох сургалтуудад байнга хамруулж байна.

Цааш нь хүний нөөц, хөдөлмөрийн харилцааны тухай тайлагнав. Хүний нөөцийн татан авалтыг мэргэшсэн зуучлагчийн хөдөлмөрийн бирж болон цахим сайтаар дамжуулан хийж байна. Мэргэшсэн, нарийн мэргэжлийн ажил горилогчийг ажлын байраар ханган ажилласнаар тогтвор суурьшилт 89,7 хувьтай болсон юм. Тайлант онд дотооддоо ажлын байран дээрх сургалтуудыг тасралтгүй явуулж байсан бөгөөд сургалтанд ажилтан, албан хаагчид 100 хувь хамрагдаж байсныг цохон хэлэхэд таатай байна. Ажилтан, албан хаагчдын нийгмийн асуудал, сургалт, хөгжлөөс гадна ахмад настануудаа тайлант онд 2 удаа хүлээн авч хүндэтгэл үзүүлсэн бөгөөд 8,6 сая төгрөгийг зарцууллаа.

Ажлын байрны орчныг дотоодын нөөц бололцоо ажилтнуудынхаа хүчээр засварлаж хөдөлмөрлөх таатай орчин бүрдүүлэхэд анхаарч ажилласан. Механик цехийн ажилтнууд 6,8 төгрөгийн засварын ажлыг өөрсдийн нөөц бололцоогоо ашиглан хийж гүйцэтгэлээ.

Үйлдвэрчний эвлэлийн хороотой байгуулсан хамтын гэрээнд тусгагдсан идэвхижүүлэлтийн хүрээнд нийт ажилтнуудынхаа дунд спорт, урлаг уран сайхны төрөл бүрийн арга хэмжээ зохион байгуулж 21 сая төгрөгийн зардлыг гаргасан байна.

2015 онд манай хамт олноос нэлээдгүй шагнал урамшуулал ажилтан, албан хаагчид авсан тухай танилцуулав. Үүнд: Төр засаг, яам тамгын газрын хүндэт шагналаар нэлээдгүй ажилтнууд шагнагдсан байгаа. Цохон дурьдвал: Санхүү, банкны тэргүүний ажилтан цол тэмдгээр СХА-ны дарга Т.Ариунчимэг, Хүнсний тэргүүний ажилтан цол тэмдгээр технологийн ажилтан Д.Эрдэнэчимэг, Г.Очирсүх, Хүндэт жуухаар технологийн ажилтан Б.Энхзаяа, Онц тээвэрчин цол тэмдгээр жолооч, борлуулагч Л.Төмөрбаатар, Ц.Пүрэвдорж, Н.Отгонбаатар, Тээврийн яамын жуух бичгээр Д.Баярмагнай нар шагнагдсан.

Мөн тэрээр цааш нь “Атар-Өргөө” ХК нь зохистой засаглалыг хэрэгжүүлэх, үйл ажиллагааны бүх түвшинд эрсдэлийн удирдлагыг идэвхжүүлэх, эрсдэлд суурилсан дотоод хяналт шалгалтын тогтолцоог бий болгоход онцгой анхаарч ажиллалаа.

Тайлант онд улсын томоохон үзлэг шалгалтууд хуваарийн дагуу манай компанид орсон. Онцгой байдал, мэргэжлийн хяналтын байгууллагуудын хамтарсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нэгдсэн шалгалт, авто машины аюулгүй бүрэн бүтэн байдлын шалгалт, архив бичиг хэргийн нэгдсэн шалгалтуудад тус тус шалгуулсан бөгөөд манай хамт олон 85 хувиас дээш үнэлгээг тухайн шалгалтаас авсан нь бидний ажлын амжилтуудын нэгээхэн хэсэг гэж үзэж байна.

2016 онд компани өнгөрсөн сүүлийн 3 жилийн үйл ажиллагааны ололт амжилтаа бататган, хэрэглэгчдийн хүрээг өргөжүүлж салбарынхаа зах зээлд эзлэх өөрийн байр суурийг нэмэгдүүлэхийн төлөө ажиллаж байгаа зэргийг тохон хэлснээр тайланг өндөрлөв.

Хурлын дарга дотоод журмын дагуу 2015 он санхүүгийн тайланг тавиулахаар Ерөнхий нябо О.Лхагвасүрэнг тайлан тавихыг урив.

О.Лхагвасүрэн- 2015 оны эдийн засгийн гол үзүүлэлтүүдийг задлан тайлагнав. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт, борлуулалтын талаарх тоон баримтуудыг дэлгэрэнгүй танилцуулав. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт борлуулалт өмнөх оноос тайлант онд 1,3 хувиар өссөн. Энэ нь үр ашгийн тайлангаар нийт орлого 5,8 хувиар өссөн боловч нийт зардал 7,7 хувиар нэмэгдсэн тухай хэллээ. Нэгжид ногдох бэлэн бүтээгдэхүүний өртөг 84,2 төгрөгөөр буюу 5,9 –иар, борлуулалт маркетинг, удирдлагын зардал 59,7 төгрөгөөр нэмэгдсэн нь нөлөөлсөн тухай хэлсэн. Үндсэн хөрөнгөнд дахин үнэлгээ хийлгэсэн тухай цохон тэмдэглэв. Нийт хөрөнгийг өмнөх оноос 20 хувиар өсгөсөн буюу 10,4 тэрбум төгрөгийн хөрөнгөтэй болсноо мэдэгдэв. Мөн тэрээр хөрөнгө оруулсан 530 сая төгрөгөөр 29 нэр төрлийн тоног төхөөрөмж болон бусад худалдан авалтыг тус бүрээр танилцуулав. Борлуулалтын орлого өртөг зардлын бүтэц, нийт зардлын бүтэцийн өөрчлөлт, тайлангийн үеийн ашиг хуримтлагдсан ашиг, санхүүгийн байдал, өр авлага, төсвийн төлөлтийн талаар дэлгэрэнгүй танилцуулав. Тайланг бүрэн эхээр нь хурлын материалд хавсаргав. Борлуулалтын авлагыг өмнөх онтой харьцуулахад 14,1 сая төгрөгөөр буюу 7 хувиар өссөн байгаа тухай тэмдэглэн хэллээ. 2015 онд зарим бүтээгдэхүүний үнэ нэмэгдсэнтэй холбоотой гэж үзсэнээ цохон хэлэв. Бэлтгэн нийлүүлэгчид болон бусад харилцагчаас авах авлагыг дэлгэрэнгүй танилцуулав.

Цааш нь ТУЗ-ийн дэд хороо болох Аудитын хорооны дарга Б.Мөнхзаяа тайлант онд хийгдсэн ажил болон үйл ажиллагааны талаарх дүгнэлтийн талаарх мэдээлэл хийв.

Б.Мөнхзаяа- Тэрээр 2015 онд ТУЗ нь тогтмол хугацаанд хуралдаж үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг цаг алдалгүй хэлэлцэн шийдвэрлэж ирлээ. 2015 оны жилийн эцсийн үйл ажиллагаа санхүүгийн тайланд ТУЗ-ийн дэргэдэх аудитын хорооны дарга, гишүүдийн дүгнэлтийг уншиж танилцуулав. Үүнд:

- Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн жигд, тасралтгүй явагдаж байсан бөгөөд цалин хөлсийг тогтмол хугацаанд олгож байсан, компанийн үйл ажиллагааг өргөтгөх зорилгоор төслийн менежерийн орон тоог бий болгосн ажиллаж байгаа
- Өнгөрсөн онд банкнаас зээл аваагүй өөрийн хөрөнгөөр үйл ажиллагаагаа өргөтгөхөөр 530 сая төгрөгийн зарцуулсан
- Борлуулалтын хэмжээ өмнөх оноос 11 хувиар буурсан байсан ч тайлант онд 3 хувиар өссөн үзүүлэлттэй байгаа. Эдийн засгийн таагүй орчинтой холбоотой байж болох ч компанийн удирдлага борлуулсан бүтээгдэхүүний өртөгийг бууруулж нийт ашгийг өмнөх оноос 11 хувиар өсгөж чадсан төдийгүй зохих хэмнэлтийг хийж чадсан гэж үзэж байгаагаа хэлсэн.
- Үйл ажиллагааны зардлыг хувь нийлүүлэгчдийн хөрөнгийн өгөөж 12 хувь гарсан ба нэгж хувьцаанд ногдох ашгийн хэмжээг 4332 төгрөгт хүргэж чадсан төдийгүй өмнөх оноос өсөлттэй байгаа гүйцэтгэх удирдлагын хувьд тодорхой амжилт гаргасан гэж үзсэн тухайгаа хэлсэн.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа хэвийн жигд явагдаж байгаа бөгөөд хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг компанийн удирдлага хангаж ажиллаж байна гэж үзсэн болно.

Б.Мөнхдалай- Дотоод журмын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлд нэр дэвшиж байгаа хүмүүсийг товч танилцуулгыг хийлээ. Нэр дэвшигчид: Б.Мөнхдалай, Ж.Тогтохбаатар, Б.Ганбат, Ч.Тогтохбаатар, Ж.Сайнбилэг, Д.Гончигдорж, Г.Баттулга, В.Баттуяа, П.Аюурзана, Д.Даваадорж, Б.Мөнхзаяа, Б.Бямбахорол нарыг танилцууллаа.

Санал шүүмжлэлийг эхлүүлээд хурлын дэгийн дагуу саналын хуудсыг бөглөхөөр хуралд оролцогсод шийдвэрлэв.

За санал шүүмжлэлээ эхлүүлэе гэж Б.Мөнхдалай хэллээ. Нэлээдгүй хугацаа өнгөрлөө. Санал шүүмжлэл хэлэх хүн байгаа эсэхийг дахин тодруулав. Хуралд оролцогсод санал шүүмжлэл байхгүй гэснээр гар өргүүлэн 100 хувийн саналаар санал шүүмжлэлийг таслан хурлыг үргэлжлүүлэв.

Хурлын дотоод журмын дагуу саналын хуудсаа бөглөж комисст хүргүүлэхийг мэдэгдэв. Хуралд оролцогсод хурлаар хэлэлцсэн асуудал тус бүрээр саналын хуудсаа бөглөхөөр 10 минутын завсарлага авлаа. /11 цаг 40 минут/

Тооллогын комисс 11 цаг 50 минутад саналын хуудсыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдээс хураан авч тооллогын ажлыг эхлүүлэв.

12 цаг 10 минутад тооллогыг комисс саналын хуудсыг тоолж дуусган тооллын комиссын дарга Н.Паламдорж тогтоолыг уншиж танилцуулав.

Хэлэлцсэн асуудал тус бүрээр хувьцааны саналын хувийг ТУЗ-ийн гишүүдийг сонгохдоо кумулятив аргаар санал авахаа хуралд оролцогсодод танилцуулж тайлбарлаж өгсөн бөгөөд кумулятив аргыг хэрхэн ашиглаж санал өгөх тухай гарын авлага болгон тараасныг уламжлав. Мөн санал өгсөн Ард капитал брокерийг төлөөлж 1 харилцагч 1 саналын эрхтэйгээр хуралд оролсон төдийгүй итгэмжлэлээр оролцсон 2 хүн байгааг цохон хэлсэн. Хурлаар хэлэлцсэн асуудал тус бүрээр авсан саналыг нэгтгэн танилцуулав. 20 харилцагчийн 157980 хувьцааны

саналын хуудсыг тоолоход хүчингүй саналын хуудас байхгүй байна гээд дараах хэлэлцсэн асуудал тус бүрээр саналын хуудсыг танилцуулав.

№	Хэлэлцэх асуудал	Зөвшөөрсөн		Түдгэлзсэн		Татгалзсан	
		Хувьцааны санал	Хувь	Хувьцааны санал	Хувь	Хувьцааны санал	Хувь
1	Компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн 2015 оны ажлын тайланг батлах	157980	100				
2	Зохион байгуулалтын асуудал ТУЗ-ийн гишүүдийг сонгох						
Ердийн гишүүн							
3	2.1 Б.Мөнхдалай	157970	99,99				
	2.2 Б.Ганбат	157970	99,99				
	2.3 Ж.Сайнжаргал	158029	100,03				
	2.4 Ч.Тогтохбаатар	69896	44,24				
	2.5 Г.Баттулга	97264	61,57				
	2.6 Д.Гончигдорж	157842	99,91				
	2.7 Ж.Сайнбилэг	148920	94,26				
	2.8 В.Баттуяа	128	0,08				
	Хараат бус гишүүн						
	2.9 П.Аюурзана	157628	99,77				
	2.10 Б.Мөнхзаяа	70332	44,5				
	2.11 С.Бямбахорол	148893	94,24				
	2.12 Д.Даваадорж	97087	61,45				
4	2015 оны цэвэр ашгаас " Ногдол ашиг хуваарилах тухай " ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах	157980	100				
5	Компанийн удирдлагын болон үйл ажиллагааны 2016 оны зардлын төсөв батлах	157980	100				

Шийдвэрлэсэн асуудал тус бүрээр дараах шийдвэрийг гаргав. Үүнд:

1. 2015 оны үйл ажиллагааны тайлан болон санхүүгийн тайлан тэнцлийг 157980 хувьцаа буюу 100 хувь
2. Зохион байгуулалтын асуудал

Ердийн гишүүнээр:

1. Б.Мөнхдалай
2. Б.Ганбат
3. Ж.Сайнжаргал
4. Ж.Сайнбилэг
5. Г.Баттулга
6. Д.Гончигдорж

Хараат бус гишүүнээр:

7. С.Бямбахорол
8. Д.Даваадорж
9. П.Аюурзана

3. Ногдол ашиг нэгж хувьцаанд 300 төгрөг олгох
4. 2016 оны Компанийн удирдлагын болон үйл ажиллагааны зардлын төсөв батлах

Батлав. Тооллогын комиссын дарга



Гишүүд

Н.Паламдорж

В.Баттуяа

Д.Гончигдорж

Хувь нийлүүлэгчдийн бүх гишүүдийн хурлаас шийдвэрлэсэн нь:

1. Компанийн 2015 оны Төлөөлөн удирдах зөвлөлийн болон санхүүгийн тайлан тэнцлийг зөвшөөрөн батлах
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн Ердийн гишүүнээр: Б.Мөнхдалай, Б.Ганбат, Ж.Сайнжаргал, Ж.Сайнбилэг, Г.Баттулга, Д.Гончигдорж Хараат бус гишүүнээр: С.Бямбахорол, Д.Даваадорж, П.Аюурзана нарыг тус тус сонгох
3. 2015 оны үйл ажиллагааны цэвэр ашгаас ногдол ашиг нэгж хувьцаанд 300 олгох
4. 2016 оны удирдлагын болон үйл ажиллагааны зардлын төсвийг 3 219 001,40 мянган төгрөгөөр зөвшөөрөн батлах

Тооллогын комиссын тогтоолыг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хурлаас гарах шийдвэрийн төсөл буюу ХНХ-ын тогтоол 1,2,3,4 –г хурлын тэргүүлэгч Б.Мөнхдалай уншиж танилцуулан хуралд оролцсон хувьцаа эзэмшигчид санал нэгтэй гар өргөн батлав.

12 цаг 45 минутад хурал хаасныг хурлын дарга Б.Мөнхдалай мэдэгдэж ТУЗ-д сонгогдсон гишүүдийг ТУЗ-ийн даргын өрөөнд хуралд урив.

“АТАР-ӨРГӨӨ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛИЙГ ХӨТӨЛСӨН

ХУРЛЫН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН ХЭСЭГ:

П.ОЮУН-ЭРДЭНЭ

Л.ЭНХСАЙХАН

ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛТЭЙ ТАНИЛЦСАН ХУРЛЫН

ДАРГА Б.МӨНХДАЛАЙ

